

67



Б Н М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 14

№ 344

Улаанбаатар хот

Компани байгуулах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газрыг БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийн дагуу Орон сууц, нийтийн аж ахуйн компани /УҮГ/ болгон байгуулсугай.

2. Орон сууц, нийтийн аж ахуйн компани /УҮГ/-ийн цүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. Сангийн яамны 1991 оны 03/1142 тоот албан бичгийг үндэслэн бие цаасан тайлан тэнцэл бүхий аж ахуйн нэгжээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэн ажиллуулахыг Орон сууц, нийтийн аж ахуйн компани /н.Бямбаа/-д цаалгасугай.

4. Орон сууцны байгууллагууцны ажил, үйлчилгээний онцлог, хөрөнгийн чацварыг нь харгалзан орон сууцны фонцыг хувьчилж өхлөх хүртэл улсын татварыг аж ахуйн нэгж бүрээр тусад нь тооцож байгаа одоогийн халбэрээр төлж байх асуудлыг холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэхийг Хотын санхүүгийн газар /н.Гонгор/-т цаалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны харьяа байгууллагууцны удирдлага, зохион байгуулалт, цалингийн санг батлах тухай" Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны I дүгээр сарын 6-ны өдрийн 2 дугаар тогтоолыг "нэг"-ийн I?, "Дүрэм батлах тухай" 1991 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА 2

ХӨРӨН ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭБИШ

Н.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын
Гүйцэтгэх захиргааны 1991 оны
...344/... тоот тогтоолын хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН
КОМПАНИ "УҮГ" - ИЙ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйн компани "УҮГ" / энэ дүрмэнд цаашид "компани" гэнэ / нь хотын хэмжээнд орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх, салбарын хэмжээнд өмч хувьчлалын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, засвар, үйлчилгээний материаллаг баяныг бэхжүүлэхтэй холбогдсан асуудлаар нэгдсэн бодлого явуулж төрийн өмчид тулгуурлан ажиллах улсын үйлдвэрийн газар бөгөөд аж ахуйн нэгжийнхөө үйл ажиллагааг зохицуулж удирдана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2. Компани нь аж ахуйн бүрэн тооцсон дээр бие даан ажиллах орон сууц, нийтийн аж ахуйн конторууд, Халдун усны захиргаа, Барилга засвар үйлчилгээний контор, Гадаадын мэргэжилтэнд үйлчлэх контор, "Гал голомт" нүүс зэрэг улсын үйлдвэрийн газар болох аж ахуйн нэгжүүдтэй ажиллана.

3. Компани нь үйл ажиллагаандаа ЕНМАУ -н хууль тогтоомж, Улаанбаатар хотын Ардын Хурлын Тэргүүлэгчид, Гүйцэтгэх захиргааны гаргасан эрх зүйн акт, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

4. Компани нь бие даасан цанстай, тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмцэг, албан бичгийн хэвлэмэл хуучас хэрэглэж тушаал гаргана. Компаний үйл ажиллагааг захирал удирдаж Улаанбаатар хотын Ардын Хурал, Гүйцэтгэх Захиргааны өмчө ажил хариуцаж тайлагнана.

5. Компаний захирлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаа гэрээний үндсэн дээр томилно.

6. Компани нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлтөй байна.
Зурав. Компанийг байгуулах, сүртгэх

7. Компанийг Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны шийдвэрээр байгуулна.

169

2.

8. Компани, түүний аж ахуйн нэгжүүд нь татварын улсын албанд бүртгүүлнэ.

Дөрөв. Компаний эд хөрөнгө

9. Компаний эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ. Уг эд хөрөнгөө ЕНМАУ -ын хууль тогтоомж болон дүрмэндээ нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн цагуу эзэмшин ашиглаж захиран зарцуулна.

10. Компанийн дүрмийн сангийн хэмжээ 2,3 тэрбум төгрөг байна.

Тав. Компаний үүрэг

11. Аж ахуйн нэгжийг сайгуулах, татан буулгах, өөрчлөх асуудлыг бие даан шийдвэрлэнэ. Аж ахуйн нэгжийн даргыг гэрээний үндсэн дээр компаний захирал томилно.

12. Компани нь Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн салбарын эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

13. Компани нь орон сууц, нийтийн аж ахуйн барилга сайгууламжийн ашиглалт, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээнд шинжлэх ухаан техникийн ололтыг нэвтрүүлэх бодлого боловсруулан түүнийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

14. Аж ахуйн нэгжүүдийн тайлан тэнцэтгэл, статистикийн болон үйлчилгээний мэдээг сар, улирал, жилээр авч нэгтгэн холбогдох сайгууллагуудад үнэн зөв тогтмол мэдээлж байх, санхүү аж ахуйн үйл ажиллагаанд шинжилгээ судалгаа, хяналт шалгалт хийж шаардлагатай арга хэмжээ авна.

15. Компани нь аж ахуйн нэгжийнхээ албан татварыг аж ахуйн нэгж бүрээр тооцон авч төвлөрүүлж Улаанбаатар хотын санхүүгийн газартай шууд харилцана.

16. Компани нь үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх үйлчилгээнд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, орон сууц

3.

нэгдсэн журмаар барих, худалдан авах, тэргүүний ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах, улирлагын зарцлыг санхүүжүүлэх, гачигдал тохиолдсон хүүхдэд тэтгэмж олгох зэрэг зорилгоор аж ахуйн нэгжүүдийн ашгаас байгуулсан хөрөнгөөс 50 хүртэл хувиар төвлөрүүлж зарцуулна.

17. Аж ахуйн нэгжүүдийн мөхөлд байгаа барилга, үндсэн хөрөнгийг тайлан тэнцэтгэлээс тайлан тэнцэтгэлд шилжүүлэх, актлах, түүнчлэн их засварын хөрөнгийн аж үүсвэр хүрэлцэхгүй нөхцөлд аж ахуйн нэгжүүдийн хооронд зохицуулалт хийнэ.

18. Улсын үнэ тарифь тогтоогдоогүй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд мөрдөх үнэ, тарифь, техникийн нөхцөлийг боловсруулж батлах, шаардлагатай бол холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлнэ. Үнэ, тарифын мөрдөлтөнд хяналт тавина.

19. Хотын орон сууцыг ус, дулаан, сахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангуулах, үйлчилгээний цэг сэлбэр, нэр төрлийг нэмэгдүүлэх, зөв байрлуулах арга хэмжээ авна.

20. Орон сууц, үйлчилгээний төв болон дулааны нэгдсэн төв, халуун усны барилга, тэдгээрийн халаалтын зуух зэрэг барилга байгууламжийг ашиглалтад хүлээж авахад оролцон техникийн дүгнэлт гарган холбогдох акт, баримт бичигт гарын үсэг зурна.

21. Орон сууц, нийтийн аж ахуйн барилга байгууламжинд техникийн үзлэг, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх болон их, урсгал засвар тохижилтын ажлыг тогтоосон журмын дагуу явуулахад аж ахуйн нэгжүүдэд байнгын хяналт тавина.

22. Аварь засвар үйлчилгээний ангийн ажлыг шууд удирдан зохион байгуулж, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээнд техник технологийн зохистой горим нэвтрүүлж, тэдгээрийн ашиглалтыг сайжруулах, гарсан аваргийг шуурхай арилгах нөхцөлийг хангуулах, механик цехийн хүч чацлыг бүрэн ашиглаж сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. Орон сууцны засварын үйлдвэрлэлийн баазыг өргөтгөн сэхжүүлэх чиг боцлогыг хэрэгжүүлнэ.

181

4.

23. Системийн хэмжээний материал техникийн хангамжийн асуудлыг нэгтгэн зохион байгуулна.

24. Шинжлэх ухаан техникийн дэвшил, шинэ техник, технологийг орон сууц, нийтийн аж ахуйн хэмжээнд нэвтрүүлэх, энэ чиглэлээр заавар зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулна.

25. Аж ахуйн нэгжүүдийг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, удирдах ажилтныг шилж сонгох, тэдний мэргэжил мөцлэгийг дээшлүүлэх, шинээр мэргэжилтэн бэлтгэх зэргээр боловсон хүчний бодлогыг системийн хэмжээнд нэгтгэн явуулна.

Зургаа. Компаний эрх

26. Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэднээс шаарцлагатай материал, мөцээ судалгааг гаргуулан авна.

27. Аж ахуйн нэгжүүд нь хууль тогтоомжинд нийцээгүй буюу хөдөлмөрчил, нийгмийн эрх ашигт кэршилсэн гушаал шийдвэр гаргавал түүнийг цуцлана.

28. Аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтны илтгэл сонголыг авч хэлэлцэнэ. Тэдгээрээс зөрчил гаргавал зохих хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

29. Гадаад орны болон холбогдох байгууллагуудтай тогтоосон журмын дагуу харилцаж тогтоон хамтран ажиллана.

30. Аж ахуйн нэгж, хүмүүсийн дунд төрөл бүрийн уралдааныг зохион байгуулан байр эзлүүлж шагнаж урамшуулна.

Долоо. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

31. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.